



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 10 сарын 08 өдөр

Дугаар 336


Улаанбаатар хот

“Мэдээлэл-Аудит” ХХК-ийг үнэт цаасны зах зээлд оролцогчид
аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.17, 24.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 452 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай” журмын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Мэдээлэл-Аудит” ХХК-ийг үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэсүгэй.
2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Мэдээлэл- Аудит” ХХК /Д.Товуудорж/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН